8.25. Алтны хэмжээ нь

$$3 \cdot 50\% = 60\% \cdot x + 30\% \cdot (3 - x)$$

тул $150 = 60x + 90 - 30x \Rightarrow x = 2$ кг болно.

9. Функци, Уламжлал, Интеграл 1

9.1. $f(-2) = (-2)^2 + 1 = 5$ тул $g(f(-2)) = g(5) = 2 \cdot 5 - 7 = 3$ байна.

9.2. Утгын муж нь $[0; 2]$ байхын тулд $f(-1) = 0$ ба $f(1) = 2$, эсвэл $f(-1) = 2$ ба $f(1) = 0$ байна. Нөгөө талаас $f(1) = a + b$ тул $a + b$ нь 0 эсвэл 2 гэсэн утгуудыг авах боломжтой юм.

9.3.

$$y' = (2x + 1)' = 2$$

9.4.

$$y' = [(2x + 3)^4]' = 2 \cdot 4(2x + 3)^{4-1} = 8(2x + 3)^3$$

9.5.

$$y' = (2^x)' = (e^{(\ln 2)x})' = e^{(\ln 2)x} \cdot [(\ln 2)x]' = 2^x \cdot \ln 2$$

9.6. Өнцгийн коэффициент нь $\text{tg} 45^\circ = 1$ байна.

9.7. $y' = 2x$ тул $f(5) = 5^2 = 25$ ба $f'(5) = 2 \cdot 5 = 10$ байна. Иймд шүргэгч шулууны тэгшитгэл нь

$$y = 10(x - 5) + 25 \Rightarrow y = 10x - 25$$

байна.

9.8.

$$y = 2\sqrt{x} = 2x^{\frac{1}{2}} \Rightarrow y' = 2 \cdot \frac{1}{2} \cdot x^{\frac{1}{2}-1} = \frac{1}{\sqrt{x}}$$

тул $x_0 = 1$ абсцисстай цэгт татсан шүргэгчийн өнцгийн коэффициент нь $\frac{1}{\sqrt{1}} = 1$ байна.

Өнцгийн коэффициент нь OX тэнхлэгийн эерэг чиглэлтэй үүсгэх өнцгийн тангес тул уг өнцөг нь 45° байна.

9.9.

$$y' = 2x^2 - 2x - 4 > 0 \Leftrightarrow 2(x+1)(x-2) > 0$$

болно. Эндээс

$$\left\{ \begin{array}{l} x+1 > 0 \\ x-2 > 0 \end{array} \right. \cup \left\{ \begin{array}{l} x+1 < 0 \\ x-2 < 0 \end{array} \right.$$

болох тул $x \in]-\infty; -1[\cup]2; +\infty[$

9.10. $f(x) = \frac{x^3}{3} - 0.5x^2 - 12x$ функцийн буурах муж нь $f'(x) = x^2 - x - 12 < 0$ тэнцэтгэл бишийн шийдийн муж байна.

$$x^2 - x - 12 < 0 \Leftrightarrow (x+3)(x-4) < 0$$

тул $] -3; 4[$ мужид буурах тул шийдийн мужийн урт нь $4 - (-3) = 7$ байна.

9.11. $f(x) = x^2 - 4x + 10 = (x-2)^2 + 6 \geq 6$ ба $x = 2$ үед

$$f(2) = 2^2 - 4 \cdot 2 + 10 = 6$$


хамгийн бага утгаа авна.

9.12.

$$f'(x) = 3(x-4)(x-2)$$

тул $x = 4$ дээр минимумтай, $x = 2$ цэг дээр максимумтай. Иймд максимум утга нь

$$f(2) = (2-4)^2 \cdot (2-1) = 4$$



9.13. $2(x+y) = 16 \Rightarrow y = 8-x$ тул талбай нь $S(x) = x(8-x) = 8x - x^2$ болно.
 $S'(x) = 8 - 2x = 0 \Rightarrow x = 4$ тул хамгийн их утга нь

$$S(4) = 4 \cdot (8-4) = 16.$$

9.14.

$$S(t) = 2t \cdot f(4+t) = 2t(4+t-1)(7-t-4) = 2t(9-t^2)$$

ба

$$S'(t) = 2(9-t^2) + 2t(-2t) = 18-6t^2 = 0 \Rightarrow t = \pm\sqrt{3}$$

болно. $t > 0$ тул $t = \sqrt{3}$ үед функц хамгийн их утгаа авна. Иймд

$$\max_y S = 2 \cdot \sqrt{3} \cdot (9 - (\sqrt{3})^2) = 12\sqrt{3}$$

y

$$f(4+t)$$

S

x

$$1 \quad 4-t \quad 4 \quad 4+t \quad 7$$

9.15. $\int (x-1)(x-2) dx = \int x^2 - 3x + 2 dx = \frac{x^3}{3} - \frac{3x^2}{2} + 2x + C$ байна.

9.16.

$$\int \frac{1}{x^2} dx = \int x^{-2} dx = \frac{x^{-2+1}}{-2+1} + C = -\frac{1}{x} + C$$

9.17. $(e^{2x} + C)' = e^{2x} \cdot (2x)' + 0 = 2e^{2x}$ тул

$$\int 2e^{2x} dx = e^{2x} + C$$

байна.

9.18.

$$\int_1^2 (x^2 - 3x + 2) dx = \int_1^2 (x-1)(x-2) dx = \frac{(1-2)^3}{6} = -\frac{1}{6}$$

9.19.

$$\int_3^{3e^4} \frac{1}{2x} dx = \frac{1}{2} \ln x \Big|_3^{3e^4} = \frac{1}{2} (\ln(3e^4) - \ln 3) = \frac{1}{2} \ln \frac{3e^4}{3} = \frac{1}{2} \ln e^4 = 2$$

байна.

9.20. $\int \sin x \, dx = -\cos x + C$ тул

$$\int_0^{\frac{\pi}{2}} \sin x \, dx = -\cos \frac{\pi}{2} - (-\cos 0) = 1$$

байна.

9.21.

$$\begin{aligned} \int_0^4 |x-2| \, dx &= \int_0^2 |x-2| \, dx + \int_2^4 |x-2| \, dx \\ &= \int_0^2 -(x-2) \, dx + \int_2^4 (x-2) \, dx \\ &= -\int_0^2 (x-2) \, dx + \int_2^4 (x-2) \, dx \\ &= -\left. \frac{(x-2)^2}{2} \right|_0^2 + \left. \frac{(x-2)^2}{2} \right|_2^4 \\ &= -(0-2) + (2-0) = 4 \end{aligned}$$

9.22. $y = 2x^2 - 2x - 1.5$ параболын $y = 0$ шулуунтай огтлолцох цэгүүдийг олж.

$2x^2 - 2x - 1.5 = 0$ тул

$$x_{1,2} = \frac{2 \pm \sqrt{2^2 - 4 \cdot 2 \cdot (-1.5)}}{2 \cdot 2} = \frac{2 \pm 4}{4}$$

буюу $x_1 = -0.5$, $x_2 = 1.5$ абсцисстай цэгүүдээр огтлолцоно.

$$\begin{aligned} S &= -\int_{-0.5}^{1.5} (2x^2 - 2x - 1.5) \, dx = -\int_{-0.5}^{1.5} 2(x+0.5)(x-1.5) \, dx \\ &= \frac{2}{6} \cdot (1.5 - (-0.5))^3 = \frac{8}{3} \end{aligned}$$

болно.

9.23. $x^2 = x + 2$ тэгшитгэлээс $\alpha = -1$, $\beta = 2$ гэж огтлолцлын цэгийн абсцисс олдох тул томьёо ёсоор олох талбай

$$-\int_{-1}^2 (x+1)(x-2) \, dx = \frac{(2-(-1))^3}{6} = \frac{9}{2}$$

байна.

9.24.

$$V = \pi \int_0^1 (\sqrt{x})^2 \, dx = \pi \int_0^1 x \, dx = \pi \cdot \left. \frac{x^2}{2} \right|_0^1 = \frac{\pi}{2}$$

9.25.

$$f(x) = -2x^3 - 3x^2 + 12x \Rightarrow f'(x) = -6x^2 - 6x + 12$$

ба $-6(x^2 + x - 2) = 0 \Rightarrow x_1 = -2$, $x_2 = 1$ болно. $-6 < 0$ тул $x = -2$ цэг дээр минимум, $x = 1$ цэг дээр максимум утга авна. Иймд минимум утга нь

$$f(-2) = -2 \cdot (-2)^3 - 3 \cdot (-2)^2 + 12 \cdot (-2) = -20$$

максимум утга нь

$$f(1) = -2 \cdot 1^3 - 3 \cdot 1^2 + 12 \cdot 1 = 7$$

тул зөрөө нь $7 - (-20) = 27$ байна.

10. Алгебр сэдвийн давтлага 1

10.1. $(x+1)$ -д хуваахад гарах үлдэгдэл нь тогтмол тоо тул

$$R(x) = R(-1) = P(-1) = (-1)^{2017} + (-1) + 1 = -1$$

байна.

10.2. $x^2(x^2-5) - (x^2-2)^2 + x(x-2) = x^4 - 5x^2 - (x^4 - 4x^2 + 4) + x^2 - 2x = -2x - 4$ тул 1 зэргийн олон гишүүнт байна.

10.3. Тэнцэтгэл бишийг сөрөг тоонд хуваахад тэмдэг нь эсрэгээр өөрчлөгддөг. $-2 < 0$ тул $-2x > -7 \Leftrightarrow x < \frac{-7}{-2} = \frac{7}{2}$ байна.

10.4. $a^{0.5} = x$, $b^{0.5} = y$ орлуулбал:

$$\begin{aligned} \text{Илэрх.} &= \left(\frac{2}{a^{0.5} - b^{0.5}} - \frac{2a^{0.5}}{a^{1.5} + b^{1.5}} \cdot \frac{a - a^{0.5}b^{0.5} + b}{a^{0.5} - b^{0.5}} \right) : \frac{4a^{0.5}b^{0.5}}{a - b} \\ &= \left(\frac{2}{x - y} - \frac{2x}{x^3 + y^3} \cdot \frac{x^2 - xy + y^2}{x - y} \right) : \frac{4xy}{x^2 - y^2} \\ &= \left(\frac{2^{(x+y)}}{x - y} - \frac{2x}{(x + y)(x^2 - xy + y^2)} \cdot \frac{x^2 - xy + y^2}{x - y} \right) : \frac{4xy}{x^2 - y^2} \\ &= \left(\frac{2x + 2y}{x^2 - y^2} - \frac{2x}{x^2 - y^2} \right) : \frac{4xy}{x^2 - y^2} \\ &= \frac{2y}{x^2 - y^2} : \frac{4xy}{x^2 - y^2} \\ &= \frac{2y}{x^2 - y^2} \cdot \frac{x^2 - y^2}{4xy} \\ &= \frac{1}{2x} = \frac{1}{2a^{0.5}} = \frac{1}{2} a^{-0.5} \end{aligned}$$

10.5. Пропорцийн чанараар $\frac{a-c}{b-d} = \frac{c}{d}$ байна.

10.6. $y = x^2$ параболыг $\vec{p} = (3, -4)$ векторын дагуу параллель зөөхөд

$$y = (x-3)^2 + (-4) = (x-3)^2 - 4$$

парабол гарна.

10.7.

$$(x^2 - 4)\sqrt{2x+3} = 0 \Rightarrow \begin{cases} x^2 - 4 = 0 \\ \sqrt{2x+3} = 0 \end{cases}$$

Эхний тэгшитгэлээс $x = \pm 2$, хоёр дахь тэгшитгэлээс $x = -\frac{3}{2}$ гэсэн шийд гарна. $x = -2$ үед $\sqrt{2 \cdot (-2) + 3} = \sqrt{-1}$ тодорхойлогдохгүй тул шийд болохгүй. Иймд $x_1 = -\frac{3}{2} = -1.5$, $x_2 = 2$ гэсэн шийдтэй.

10.8.

$$\frac{2}{x-1} > \frac{1}{7} \Leftrightarrow \frac{2}{x-1} - \frac{1}{7} > 0 \Leftrightarrow \frac{2 \cdot 7 - 1 \cdot (x-1)}{7(x-1)} > 0$$

байна. Эндээс

$$\frac{15-x}{x-1} > 0 \Leftrightarrow (x-1)(x-15) < 0$$

тул $1 < x < 15$ буюу $x \in]1; 15[$ байна.

10.9.

$$x^2 + 2x - 5 \geq x + 7 \Leftrightarrow x^2 + x - 12 = (x+4)(x-3) \geq 0$$

тул $x \in]-\infty; -4] \cup [3; +\infty[$ байна.

10.10. Өгсөн тэгшитгэл төгсгөлгүй олон шийдтэй байх зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл нь

$$\frac{b}{4} = \frac{1}{-2} = \frac{1}{b}$$

тул $b = -2$ байна.

10.11. $\begin{cases} 4x + ay = 1 \\ bx + 7y = 2 \end{cases}$ тэгшитгэл шийдгүй бол

$$\frac{4}{b} = \frac{a}{7} \neq \frac{1}{2}$$

байна. Эндээс $ab = 4 \cdot 7 = 28$ байна.

10.12. Тэгшитгэлийг 4^x -д хувааж $t = \left(\frac{3}{2}\right)^x$ орлуулга хийвэл

$$2t^2 = t + 3 \Rightarrow t_1 = -1, t_2 = \frac{3}{2}$$


болно. $\left(\frac{3}{2}\right)^x$ эерэг байх ёстой тул тэгшитгэл $\left(\frac{3}{2}\right)^x = \frac{3}{2} \Rightarrow x = 1$ гэсэн цор ганц шийдтэй. Иймд шийдүүдийн нийлбэр нь 1 байна.

10.13.

$$\log_{\frac{1}{2}}(x^2 + x - 2) > -2 \Leftrightarrow \begin{cases} x^2 + x - 2 < \left(\frac{1}{2}\right)^{-2} = 4 \\ x^2 + x - 2 > 0 \end{cases} \Leftrightarrow$$

$$\begin{cases} x^2 + x - 6 < 0 \\ x^2 + x - 2 > 0 \end{cases} \Leftrightarrow \begin{cases} (x+3)(x-2) < 0 \\ (x+2)(x-1) > 0 \end{cases} \Leftrightarrow \begin{cases} -3 < x < 2 \\ x < -2 \cup x > 1 \end{cases}$$

тул $x \in (-3; -2) \cup (1; 2)$ байна.



10.14. Бутархайн хуваарь тэгээс ялгаатай ба $\sin 2x = 2 \sin x \cos x$ тул

$$D: \begin{cases} \cos x \neq 0 \\ \sin x \neq 0 \\ 1 - \cos 2x \neq 0 \end{cases} \Leftrightarrow \begin{cases} \sin 2x \neq 0 \\ \cos 2x \neq 1 \end{cases}$$

үндсэн адилтгалаас $\sin 2x \neq 0$ үед $\cos 2x \neq 1$ гэж гарах тул зөвхөн $\sin 2x \neq 0$ -ийг бодоход л хангалттай. Иймд $2x \neq \pi k$ буюу $x \neq \frac{\pi k}{2}$ байна.

10.15. $\sin^2 2x = \frac{1 - \cos 4x}{2} = \frac{1}{2} \Leftrightarrow \cos 4x = 0$ байна. Иймд $4x = \frac{\pi}{2} + \pi k \Rightarrow \frac{\pi}{8} + \frac{\pi k}{4}, k \in \mathbb{Z}$ болно.

10.16. $2 \sin(\pi x) = \sqrt{3} \Leftrightarrow \sin(\pi x) = \frac{\sqrt{3}}{2}$ байна. Эндээс

$$\pi x = (-1)^k \arcsin \frac{\sqrt{3}}{2} + \pi k = (-1)^k \cdot \frac{\pi}{3} + \pi k$$

буюу

$$x = (-1)^k \cdot \frac{1}{3} + k$$


байна.

10.17. $\sin x = 2 \cos^2 x - 1 \Leftrightarrow \sin x = 2(1 - \sin^2 x) - 1$ ба $s = \sin x$ гэвэл

$$2s^2 + s - 1 = 0 \Rightarrow s_1 = -1, s_2 = \frac{1}{2}$$

болно. Иймд

$$\begin{cases} \sin x = -1 \\ \sin x = \frac{1}{2} \end{cases}$$



Эндээс $[-\pi; \pi]$ завсар дахь шийдүүд нь $-\frac{\pi}{2}, \frac{\pi}{6}, \frac{5\pi}{6}$ тул үржвэр нь

$$-\frac{\pi}{2} \cdot \frac{\pi}{6} \cdot \frac{5\pi}{6} = -\frac{5\pi^3}{72}$$

байна.


10.18. Нийлбэрийг үржвэрт хувиргах томьёо ашиглавал

$$\cos 2x + \cos 4x = 2 \cos \frac{2x + 4x}{2} \cos \frac{2x - 4x}{2} = 0$$

тул $\cos x = 0$ эсвэл $\cos 3x = 0$ болно. $\cos x = 0$ үед $\sin x = \pm 1$ тул $0 < \sin x < 1$ нөхцөлд тохирохгүй.

$$\cos 3x = 0 \Leftrightarrow 3x = \frac{\pi}{2} + \pi k \Leftrightarrow x = \frac{\pi}{6} + \frac{\pi k}{3}$$

Эдгээрийг тригонометрийн нэгж тойрог дээр дүрсэлбэл




болох ба эдгээрээс зөвхөн $\frac{\pi}{6}, \frac{5\pi}{6}$ өнцгүүд дээр синусийн утга нь $]0; 1[$ засварт байх тул тэгшитгэлийн ерөнхий шийд нь

$$x = (-1)^k \frac{\pi}{6} + \pi k$$

байна.

10.19.



$$\sin\left(3x - \frac{\pi}{6}\right) \cos\left(3x - \frac{\pi}{6}\right) < \frac{\sqrt{2}}{4} \Leftrightarrow 2 \sin\left(3x - \frac{\pi}{6}\right) \cos\left(3x - \frac{\pi}{6}\right) < \frac{\sqrt{2}}{2} \Leftrightarrow \sin\left(6x - \frac{\pi}{3}\right) < \frac{\sqrt{2}}{2}$$

тул

$$\begin{aligned} \frac{3\pi}{4} + 2\pi(k-1) < 6x - \frac{\pi}{3} < \frac{\pi}{4} + 2\pi k &\Leftrightarrow -\frac{11\pi}{12} + 2\pi k < 6x < \frac{7\pi}{12} + 2\pi k \Leftrightarrow \\ -\frac{11\pi}{72} + \frac{\pi k}{3} < x < \frac{7\pi}{72} + \frac{\pi k}{3} \end{aligned}$$

тул $x \in \left[\frac{k\pi}{3} - \frac{11\pi}{72}; \frac{7\pi}{72} + \frac{k\pi}{3} \right]$ байна.

10.20. Шийдийг шууд орлуулан шалгах нь хамгийн хялбар арга боловч энэ удаад бодолт хийе.

$$\sqrt{2-x} \cdot \log_3(10-x^2) = 0 \Leftrightarrow \sqrt{2-x} = 0 \vee \log_3(10-x^2) = 0$$

$\sqrt{2-x} = 0$ бол $x = 2$ шийд гарах ба $\log_3(10-x^2) = 0$ бол $10-x^2 = 1 \Rightarrow x = \pm 3$ байна. Гэвч $x = 3$ нь $\sqrt{2-x}$ илэрхийллийн тодорхойлогдох мужид орохгүй тул шийд болохгүй. Иймд $x = -3, 2$ гэсэн шийдтэй.

10.21. Гоожуур тус бүр цагт усан сангийн $\frac{1}{4.5}, \frac{1}{6.75}$ хэсгүүдийг дүүргэх тул хамтдаа

$$\frac{1}{4.5} + \frac{1}{6.75} = \frac{2}{9} + \frac{4}{27} = \frac{10}{27}$$

хэсгийг дүүргэнэ. Иймд нийт хэсгийг $\frac{1}{\frac{10}{27}} = 2.7$ цагт дүүргэнэ.

10.22. O нь бөмбөрцгийн төв, M нь конусын суурийн тойрог дээрх цэг гэе. OM хэрчмийн цилиндрийн гол тэнхлэгтэй үүсгэх өнцгийг θ гэвэл суурийн радиус нь $6\sin\theta$, өндөр нь $6 + 6\cos\theta$ байна. Конусын эзлэхүүн нь

$$V(\theta) = \frac{\pi}{3} (6\sin\theta)^2 (6 + 6\cos\theta)$$

ба $c = \cos\theta$, $|c| \leq 1$ гэвэл $\sin^2\theta = 1 - c^2$ тул


$$V(c) = \frac{\pi}{3} \cdot 6^3 (1 - c^2)(1 + c)$$

байна. c -ийн ямар утганд конусын эзлэхүүн хамгийн их байхыг олѐ.

$$V'(c) = 0 \Rightarrow 1 - 2c - 3c^2 = 0 \Rightarrow c_1 = -1, c_2 = \frac{1}{3}$$

болно. Эндээс $c = \frac{1}{3}$ үед $V(c)$ хамгийн их утгаа авна. Энэ үед бөмбөрцгийн төвөөс суурь хүртэлх зай $d = 6 \cdot \frac{1}{3} = 2$ см байна.


10.23.



$\int_{-2}^6 |x-2| dx$ интеграл нь будагдсан хэсгийн (2 гурвалжны) талбайтай тэнцүү тул

$$\frac{4 \cdot 4}{2} + \frac{4 \cdot 4}{2} = 16 \text{ байна.}$$

10.24.



$x > 0$ хэсэг дэх талбай нь

$$\int_0^1 (6x - 3x^3) dx = \left(3x^2 - \frac{3x^4}{4} \right) \Big|_0^1 = \frac{3}{2}$$

Иймд бидний олох талбай $2 \cdot \frac{3}{2} = 3$ байна.

10.25.

$$\begin{aligned} \sin^4 \frac{x}{2} + \cos^4 \frac{x}{2} &= \left(\sin^2 \frac{x}{2} + \cos^2 \frac{x}{2} \right)^2 - 2 \sin^2 \frac{x}{2} \cos^2 \frac{x}{2} \\ &= 1 - \frac{1}{2} \sin^2 x \\ &= 1 - \frac{1}{2} \cdot \frac{1 - \cos 2x}{2} \\ &= \frac{3}{4} + \frac{1}{4} \cos 2x < \frac{5}{8} \end{aligned}$$

болно. Эндээс $\cos 4x < -\frac{1}{2}$ болно. Үүнийг бодвол

$$\frac{2\pi}{3} + 2\pi k < 2x < \frac{4\pi}{3} + 2\pi k \Leftrightarrow \frac{\pi}{3} + \pi k < x < \frac{2\pi}{3} + \pi k, k \in \mathbb{Z}$$

Энэ шийдэд агуулагдах хамгийн бага эерэг бүхэл тоо $x = 2$, хамгийн их сөрөг бүхэл тоо $x = -2$ болно.

11. Хавтгайн геометр 1

11.1. Хурц өнцгүүдийн нийлбэр 90° тул $90^\circ - 20^\circ = 70^\circ$.

11.2. Заавар ёсоор

$$BC^2 = AB^2 + AC^2 - 2AB \cdot AC \cos \angle BAC$$

буюу

$$7^2 = 3^2 + AC^2 - 2 \cdot 3 \cdot AC \cdot \cos 120^\circ$$


байна. $\cos 120^\circ = -0.5$ тул $AC^2 + 3AC - 40 = 0$ квадрат тэгшитгэл үүснэ. Энэ тэгшитгэлийг бодвол $AC = -8$ $\vee$ $AC = 5$ болох ба $AC > 0$ байх ёстой тул $AC = 5$ байна.

Жич: Энэ бодлогын хувьд гурвалжны тэнцэтгэл бишээр А хариулт шийд биш. Мохоо өнцгийн эсрэг тал нь хамгийн урт байх ёстой тул D, E хариултууд зөв хариултууд болж чадахгүй. Иймд үлдэх 2 хариултаас зөв хариултыг тааж болох юм. Боломжгүй хариултуудыг хасаж чаддаг байх нь ЭЕШ-ийн оноогоо ахиулахад тань том тус хүргэнэ.

11.3. Гурван талынх нь урт ялгаатай тул мэдээж адил хажуут биш. $10 + 14 > 17$ тул гурвалжны талууд болно. $10^2 + 14^2 > 17^2$ тул хурц өнцөгт гурвалжин байна.

11.4. Зөв гурвалжин тул $a = b = c$, $\alpha = \beta = \gamma = 60^\circ$ байна. Иймд $2R = \frac{a}{\sin 60^\circ} \Rightarrow 4\sqrt{3} = \frac{a}{\frac{\sqrt{3}}{2}} \Rightarrow a = 6$.

11.5. АН ба ВС огтлолыг K, $\angle BAH = \beta$, $\angle BKA = \gamma$ гэе.




$\triangle AKB$ тэгш өнцөгт гурвалжнаас $BK = AB \cos \beta$, $\angle HBK = 90^\circ - \gamma$ ба $\triangle BKH$ тэгш өнцөгт гурвалжин тул

$$BH = \frac{BK}{\cos(90^\circ - \gamma)} = \frac{AB \cos \beta}{\sin \gamma} = 2R \cos \beta$$

болно. $\beta = 90^\circ - \angle BAH$ тул $\cos \beta = \sin \angle BAH = \frac{2}{5}$. Иймд

$$BH = 2R \cos \beta = 2 \cdot 4 \cdot \frac{2}{5} = 3\frac{1}{5}$$

11.6.



Тодорхойлолт ёсоор $\cos \angle ABC = \frac{BA}{BC} = \frac{6}{9} = \frac{2}{3}$ байна.

$$11.7. h = \frac{10 \cdot 24}{26} = \frac{120}{13} = 9 \frac{3}{13}.$$

11.8. Зөв гурвалжны өндөр нь $a \cdot \sin 60^\circ$ тул $m = h = 3 \cdot \frac{\sqrt{3}}{2}$ болох ба багтсан тойргийн радиус нь медианы $\frac{1}{3}$ хэсэг тул $r = \frac{m}{3} = \frac{\sqrt{3}}{2}$ байна.

11.9. Зөв гурвалжны хувьд $CH = R$ байх ба $\angle BCA = 60^\circ$ байна. Иймд D хариултаас өөр зөв хариулт байх боломжгүй.

11.10. Оройн өнцөг нь $\beta = 180^\circ - 2 \cdot 30^\circ = 120^\circ$ тул

$$S = \frac{1}{2} ac \sin \beta = \frac{1}{2} \cdot 8 \cdot 8 \cdot \sin 120^\circ = 16\sqrt{3}.$$

11.11. $p = \frac{5+6+7}{2} = 9$ тул Героны томъёогоор

$$S = \sqrt{9(9-5)(9-6)(9-7)} = 6\sqrt{6}$$

байна.

11.12. $5^2 + 12^2 = 13^2$ тул ABC нь тэгш өнцөгт гурвалжин ба талбай нь

$$S_{\triangle ABC} = \frac{5 \cdot 12}{2} = 30$$

байна. Биссектрисийн чанар ёсоор

$$\frac{BD}{AB} = \frac{DC}{AC} = \frac{BD+DC}{AB+AC} = \frac{BC}{AB+AC} = \frac{13}{17}$$

тул ABD , ABC гурвалжнууд нь ижил өндөртэй гурвалжнууд тул

$$\frac{S_{\triangle ABD}}{S_{\triangle ABC}} = \frac{BD}{BC} = \frac{\frac{13}{17} \cdot AB}{BC} = \frac{\frac{13}{17} \cdot 5}{13} = \frac{5}{17}$$


болно. Эндээс $S_{\triangle ABD} = \frac{5}{17} \cdot 30 = \frac{150}{17}$ болов.

11.13. $3^2 + 4^2 = 5^2$ тул тэгш өнцөгт гурвалжин болно. Иймд медианы урт нь $\frac{5}{2} = 2.5$ байна.

11.14. Синусын теоремоор $BC = 2R \sin \alpha = 2 \cdot 10 \cdot \frac{4}{5} = 16$ байна. Гурав дахь орой нь багтаасан тойрог дээр, өндөр нь хамгийн их тул $AB = AC$ байх адил хажуут гурвалжин байна. Эдгээрийн их нь $h_a = R + R \cos \alpha = 10 + 10 \cdot \frac{3}{5} = 16$ өндөртэй тул талбайн хамгийн их утга нь


$$S_{\max} = \frac{16 \cdot 16}{2} = 128$$

байна.



11.15. $c^2 = 9^2 + 40^2 = 1681 = 41^2 \Rightarrow c = 41$ тул $r = \frac{9 + 40 - 41}{2} = 4$ байна.

11.16.



Диагоналийн урт нь $d^2 = 3^2 + 3^2$ буюу $d = \sqrt{18} = 3\sqrt{2}$. Тойргийн уртыг диаметр харицуулсан харьцаа $\frac{\ell}{d} = \pi$ тул $\ell = 3\pi\sqrt{2}$ байна.


11.17. $\frac{AF}{FE} = \frac{1}{2} \Rightarrow \frac{AF}{FE} + 1 = \frac{1}{2} + 1$ тул $\frac{AF + FE}{FE} = \frac{AE}{FE} = \frac{3}{2}$ ба $AE = \frac{3}{2}(2x + 2) = 3x + 3$.

11.18.

$$e^2 + 9^2 = 2(3^2 + 7^2) \Rightarrow e = \sqrt{35}$$

11.19. Тойрогт багтдаг тул адил хажуут байна. Хажуу талын уртыг a гэвэл тойрог

багтаадаг тул хажуу талын урт нь $2a = 25 + 9 \Rightarrow a = 17$.




Эндээс Пифагорын теорем ёсоор

$$h = \sqrt{17^2 - \left(\frac{25-9}{2}\right)^2} = 15$$

байна. Иймд талбай нь $S = \frac{25+9}{2} \cdot 15 = 255$.

11.20.



$CE = ED = CD \cdot \cos 45^\circ = 4 \cdot \frac{\sqrt{2}}{2} = 2\sqrt{2}$ тул $h = 2\sqrt{2}$, $AD = 3\sqrt{2}$ байна. Иймд талбай нь

$$S = \frac{\sqrt{2} + 3\sqrt{2}}{2} \cdot 2\sqrt{2} = 8$$

байна.

11.21. Өнцгүүдийг x , $2x$, $5x$, $4x$ гэвэл

$$x + 2x + 5x + 4x = 360^\circ \Rightarrow 12x = 360^\circ \Rightarrow x = 30^\circ$$

ба $x + 5x = 2x + 4x = 180^\circ$ тул тойрогт багтсан дөрвөн өнцөгт байна. Багтаасан тойргийн радиусыг R гэвэл

$$AC : BD = 2R \sin 60^\circ : 2R \sin 30^\circ =$$


$$= \sin 60^\circ : \sin 30^\circ = \sqrt{3} : 1$$

11.22. Зөв зургаан өнцөгт тул багтаасан тойргийн радиус нь зургаан өнцөгтийн талын урттай тэнцүү байна. Иймд $r = \frac{24}{6} = 4$ байна. Иймд дугуйн талбай 16π байна. Зөв зургаан өнцөгтийн талбай 4 талтай зөв гурвалжны талбайгаас 6 дахин их тул $6 \cdot \frac{\sqrt{3} \cdot 4^2}{4} = 24\sqrt{3}$ байна. Иймд зурааслагдсан хэсгийн талбай

$$16\pi - 24\sqrt{3}$$

байна.

11.23. Суурийн уртуудыг mx , nx гэвэл оройгоос шүргэлтийн цэгүүд хүртэлх зай $\frac{mx}{2}$, $\frac{nx}{2}$ тул хажуу талын урт нь $\frac{(m+n)x}{2}$ байна.



Нөгөө талаас трапецийн өндөр нь

$$H = 2r = \sqrt{\left(\frac{(m+n)x}{2}\right)^2 - \left(\frac{(m-n)x}{2}\right)^2} = x\sqrt{mn}$$

тул $x = \frac{2r}{\sqrt{mn}}$ байна. Иймд


$$\frac{(m+n)x}{2} = \frac{r(m+n)}{\sqrt{mn}}.$$

11.24.

$$\begin{cases} r_1 + r_2 = 7 \\ r_1 + r_3 = 8 \\ r_2 + r_3 = 9 \end{cases} \Rightarrow r_1 = \frac{7+8-9}{2} = 3$$

болно. Иймд $r_2 = 7 - 3 = 4$, $r_3 = 9 - 3 = 6$ байна.

11.25. Зургаас харахад ямааны идэж болох талбай 5 радиустай дугуйн $\frac{3}{4}$, 2 ба 3 радиустай дугуйнуудын тус бүр $\frac{1}{4}$ хэсэг байна.



Иймд

$$\frac{3}{4} \cdot 5^2 \pi + \frac{1}{4} (2^2 + 3^2) \pi = 22\pi$$

байна.

12. Огторгуйн геометр 1

12.1. $\sqrt{3}a = \sqrt{12} \Rightarrow a = \sqrt{4} = 2$. Нийт 12 ирмэг байгаа тул эдгээрийн уртын нийлбэр нь $12 \cdot 2 = 24$.

12.2. Пирамидын суурь нь $\frac{a}{2}, \frac{b}{2}$ катетуудтай тэгш өнцөгт гурвалжин; өндөр нь $\frac{c}{2}$ тул эзлэхүүн нь

$$V_1 = \frac{1}{3} Sh = \frac{1}{3} \cdot \frac{\frac{a}{2} \cdot \frac{b}{2}}{2} \cdot \frac{c}{2} = \frac{abc}{48} = \frac{V}{48} \Rightarrow \frac{V_1}{V} = \frac{1}{48}$$

байна.

12.3.

$$V = \sqrt{10 \cdot 25 \cdot 40} = 100$$


12.4. Багтсан бөмбөрцгийн радиусыг r гэе. Суурь нь r радиустай тойрог багтаасан зөв гурвалжин тул талын урт нь

$$AC = 2B_1C = 2r \operatorname{tg} 30^\circ = 2\sqrt{3}r,$$

талбай нь

$$S = \frac{1}{2} (2\sqrt{3}r)^2 \sin 60^\circ = 3\sqrt{3}r^2$$

байна.




Призмийн өндөр нь $2r$ тул хажуу гадаргуугийн талбай нь суурийн периметрийг өндрөөр үржсэнтэй тэнцүү буюу $3 \cdot 2\sqrt{3}r \cdot 2r = 12\sqrt{3}r^2$ байна. Иймд бүтэн гадаргуугийн талбай нь

$$2 \cdot 3\sqrt{3}r^2 + 12\sqrt{3}r^2 = 18\sqrt{3}r^2 = 2\sqrt{3} \Rightarrow r = \frac{1}{3}$$

байна.

12.5.



Зөв 6 өнцөгтийн талын урт нь

$$AB = OA = \frac{\sqrt{3}}{\cos 30^\circ} = \frac{\sqrt{3}}{\frac{\sqrt{3}}{2}} = 2$$


Иймд суурийн талбай нь

$$S = 6 \cdot \frac{1}{2} \cdot 2 \cdot \sqrt{3} = 6\sqrt{3}$$

Призмийн өндөр нь багтсан бөмбөрцгийн диаметр тул $h = 2\sqrt{3}$. Иймд эзлэхүүн нь

$$V = S \cdot h = 6\sqrt{3} \cdot \sqrt{3} = 18$$

12.6. a, b талтай тэгш өнцөгтийг b урттай талыг нь тойруулан эргүүлэхэд суурийн радиус нь a , өндөр нь b байх цилиндр үүснэ.




тул эзлэхүүн нь $V = \pi a^2 b$ байна. Иймд бидний олох харьцаа нь

$$\frac{\pi \cdot 15^2 \cdot 5}{\pi \cdot 5^2 \cdot 15} = 3$$

байна.

12.7. Бид 13 см радиустай тойргийн $\ell = 24$ см урттай хөвч хүртэлх зайг бодох шаардлагатай.



Төвөөс хөвч хүртэлх зайг d гэвэл Пифагорын теорем ёсоор $R^2 = d^2 + (\ell/2)^2$ байх тул

$$d = \sqrt{13^2 - 12^2} = 5$$

байна.

12.8. Зөв тетраэдрийн талын уртыг a гэвэл $\overrightarrow{CD} = \overrightarrow{AD} - \overrightarrow{AC}$ тул

$$\begin{aligned} \overrightarrow{AB} \cdot \overrightarrow{CD} &= \overrightarrow{AB} \cdot (\overrightarrow{AD} - \overrightarrow{AC}) \\ &= \overrightarrow{AB} \cdot \overrightarrow{AD} - \overrightarrow{AB} \cdot \overrightarrow{AC} \\ &= |\overrightarrow{AB}| \cdot |\overrightarrow{AD}| \cdot \cos 60^\circ - |\overrightarrow{AB}| \cdot |\overrightarrow{AC}| \cdot \cos 60^\circ \\ &= a^2 \cos 60^\circ - a^2 \cos 60^\circ = 0 \end{aligned}$$

болов. Иймд эдгээр векторуудын хоорондох өнцөг 90° байна.

12.9. Хажуу талсууд нь адил хажуут гурвалжнууд тул хажуу талсын өндрүүдийн суурь нь суурийн талуудын дундаж цэг байна. Иймд өндрүүдийн сууриар үүсэх гурвалжны талбай пирамидын суурийн талбайгаас 4 дахин бага байна.

$$V = \frac{1}{3}Sh$$

тул ижил өндөртэй пирамидуудын эзлэхүүний харьцаа нь сууриудын талбайн харьцаатай тэнцүү. Иймд бидний олох харьцаа $\frac{1}{4}$ -тэй тэнцүү.

12.10. $\sqrt{17} + 1$ урттай талыг тойрч эргэх үед өндөр нь $\sqrt{17} + 1$, суурийн радиус нь $\sqrt{17} - 1$ тул эзлэхүүн нь

$$V_1 = \frac{\pi}{3}(\sqrt{17} - 1)^2(\sqrt{17} + 1)$$


$\sqrt{17} - 1$ урттай талыг тойрч эргэх үед өндөр нь $\sqrt{17} - 1$, суурийн радиус нь $\sqrt{17} + 1$ тул эзлэхүүн нь

$$V_2 = \frac{\pi}{3}(\sqrt{17} + 1)^2(\sqrt{17} - 1)$$

ба харьцаа нь:

$$\begin{aligned} \frac{V_1}{V_2} &= \frac{\frac{\pi}{3}(\sqrt{17} - 1)^2(\sqrt{17} + 1)}{\frac{\pi}{3}(\sqrt{17} + 1)^2(\sqrt{17} - 1)} = \frac{\sqrt{17} - 1}{\sqrt{17} + 1} \\ &= \frac{(\sqrt{17} - 1)(\sqrt{17} - 1)}{(\sqrt{17} + 1)(\sqrt{17} - 1)} = \frac{18 - 2\sqrt{17}}{(\sqrt{17})^2 - 1} \\ &= \frac{9 - \sqrt{17}}{8} \end{aligned}$$

12.11. 10 радиустай тойргийн урт $2 \cdot 10\pi = 20\pi$ ба дэлгээсийн суурийн ирмэгийн урт 10π тул энэ дэлгээс маань 10 радиустай хагас дугуй болно.




Иймд талбай нь $\frac{\pi \cdot 10^2}{2} = 50\pi$.

12.12. Их дугуйн талбай нь $\pi R^2 = 144\pi$ тул $R = 12$ байна. Бөмбөрцгийн эзлэхүүн

$$V = \frac{4}{3} \cdot R^3 \pi = \frac{4 \cdot 12^3 \pi}{3} = 2304\pi$$

12.13.



Багтсан бөмбөрцгийн радиусыг r гэе. Конусын тэнхлэг огтлол авч үзвэл зурагт үзүүлсэн AFO , AEB гурвалжнууд төсөөтэй тул

$$\frac{4-r}{5} = \frac{r}{3} \Rightarrow r = \frac{3}{2}$$

Иймд бөмбөрцгийн эзлэхүүн

$$V = \frac{4\pi}{3} r^3 = \frac{4\pi}{3} \cdot \left(\frac{3}{2}\right)^3 = 4.5\pi.$$

12.14.

$$\left(\frac{-1+1}{2}; \frac{-3+7}{2}\right) = (0; 2)$$

12.15.

$$AB = \sqrt{(-3-3)^2 + (12-4)^2} = \sqrt{36+64} = 10$$

12.16. $y = kx + b$ шулуун өнцгийн коэффициент нь k . $3x + 4y = 25 \Rightarrow y = -\frac{3}{4}x + \frac{25}{4}$ тул өнцгийн коэффициент нь $-\frac{3}{4}$ байна.

12.17.

$$\begin{cases} x-2y-1=0 \\ 2x+y-7=0 \end{cases} \Rightarrow x=2y+1 \quad (*)$$

тул $2x + y - 7 = 2(2y + 1) + y - 7 = 5y - 5 = 0$. Иймд $y = 1$ ба $(*)$ -оос $x = 2 \cdot 1 + 1 = 3$ болох тул $(x; y) = (3; 1)$.

12.18.

$$\frac{x-3}{-2-3} = \frac{y-4}{3-4} \Leftrightarrow x-5y+17=0$$

12.19.

$$\begin{aligned}
 \vec{a} \cdot (\vec{a} - 3\vec{b}) &= \vec{a} \cdot \vec{a} - 3\vec{a} \cdot \vec{b} \\
 &= (2 \cdot 2 + 3 \cdot 3) - 3 \cdot (2 \cdot (-1) + 3 \cdot 1) \\
 &= 13 - 3 = 10
 \end{aligned}$$

байна.

12.20. $\alpha = \arcsin \frac{5}{13}$ гэвэл

$$\sin \alpha = \frac{5}{13}, \quad -\frac{\pi}{2} \leq \alpha \leq \frac{\pi}{2}$$

тул $\cos \alpha > 0$ буюу

$$\cos \alpha = \sqrt{1 - \sin^2 \alpha} = \sqrt{1 - \left(\frac{5}{13}\right)^2} = \frac{12}{13}$$

Иймд

$$\vec{a} \cdot \vec{b} = |\vec{a}| \cdot |\vec{b}| \cdot \cos \alpha = \sqrt{26} \cdot \sqrt{13} \cdot \frac{12}{13} = 12\sqrt{2}$$

12.21.

$$(x, y, z) - (4, -2, 1) = (1, 5, -1) \Rightarrow$$

$$(x, y, z) = (1, 5, -1) + (4, -2, 1) = (1 + 4, 5 + (-2), -1 + 1) = (5, 3, 0)$$

12.22.

$$2 \cdot (2, -1, 1) = (4, -2, 2) \Rightarrow (2, -1, 1) \parallel (4, -2, 2)$$

12.23.

$$\vec{a} \cdot \vec{b} = 4 \cdot (-5) + 2 \cdot 0 + 5 \cdot 4 = 0$$

тул эдгээрийн хоорондох өнцгийн косинус нь

$$\cos \varphi = \frac{\vec{a} \cdot \vec{b}}{|\vec{a}| \cdot |\vec{b}|} = 0$$

болно. Иймд хоорондох өнцөг нь 90° байна.

12.24.

$$1. \quad 2\vec{a} - 3\vec{b} = 2 \cdot (-3; 2) - 3(1; 1) = (2 \cdot (-3) - 3 \cdot 1; 2 \cdot 2 - 3 \cdot 1) = (-9, 1) \text{ тул } |2\vec{a} - 3\vec{b}| = \sqrt{(-9)^2 + 1^2} = \sqrt{82} \text{ болно.}$$

$$2. \quad (-7, 2) = 2(1, a) - 3(b, 2) \text{ ба } (-7, 2) = (2 - 3b, 2a - 6) \text{ болох тул}$$

$$\begin{cases} -7 = 2 - 3b \\ 2 = 2a - 6 \end{cases}$$

системийг бодвол $a = 4, b = 3$ болно.

3. $\vec{u}$ вектортой параллел нэгж вектор нь $\frac{\vec{u}}{|\vec{u}|}$ байна. Иймд $\vec{u} = (3, -4)$ гэдгээс

$$|\vec{u}| = \sqrt{3^2 + (-4)^2} = \sqrt{9 + 16} = 5$$

Олох ёстой нэгж векторыг $\vec{e}$ гэвэл

$$\vec{e} = \frac{\vec{u}}{|\vec{u}|} = \frac{1}{5} \cdot (3, -4) = \left(\frac{3}{5}, -\frac{4}{5}\right)$$

болно.

12.25. Пирамидын суурийн талбай нь

$$S = 6 \cdot \frac{1}{2} \cdot (2\sqrt{3})^2 \sin 60^\circ = 3 \cdot 4\sqrt{3} \cdot \frac{\sqrt{3}}{2} = 18$$

тул эзлэхүүн нь

$$V = \frac{1}{3}Sh = \frac{1}{3} \cdot 18 \cdot 5 = 30$$

13. Геометр сэдвийн давтлага 1

13.1. Гурав дахь талын урт нь дундаж шугамаасаа 2 дахин их буюу 10 см байна. Иймд гурвалжны талуудын урт 9, 10, 17 болно. Косинусын теоремоор

$$\cos \alpha = \frac{10^2 + 17^2 - 9^2}{2 \cdot 10 \cdot 17} = \frac{77}{85}$$


ба

$$\sin \alpha = \sqrt{1 - \frac{77^2}{85^2}} = \frac{\sqrt{85^2 - 77^2}}{85} = \frac{36}{85}$$

болно. Иймд синусын теоремоор

$$R = \frac{a}{2 \sin \alpha} = \frac{9}{2 \cdot \frac{36}{85}} = \frac{85}{8}$$

13.2.




$$AC_1 = AC \cos \alpha = b \cos \alpha,$$

$$AH = \frac{AC_1}{\cos(90^\circ - \beta)} = \frac{b \cos \alpha}{\sin \beta} = \frac{b}{\sin \beta} \cdot \cos \alpha = 2R \cos \alpha$$

13.3. Биссектрисийн чанар ёсоор

$$\frac{BM}{AB} = \frac{CM}{AC} \Leftrightarrow \frac{x}{13} = \frac{x - 5\frac{1}{3}}{5} \Leftrightarrow 5x = 13x - \frac{16 \cdot 13}{3}$$

буюу $8x = \frac{16 \cdot 13}{3}$ тул $x = \frac{26}{3}$ байна.



13.4. Талын уртыг a гэвэл параллелограммын чанар ёсоор

$$2(a^2 + a^2) = 6^2 + 8^2 \Rightarrow a = 5$$

байна.

13.5. Пифагорын теоремоор нөгөө катетын урт нь $\sqrt{13^2 - 5^2} = 12$ байна. Их хурц өнцгийн оройгоос татсан биссектрис нь эсрэг талаа $\frac{5 \cdot 12}{5 + 12} = \frac{10}{3}$, $\frac{13 \cdot 12}{5 + 12} = \frac{26}{3}$ урттай хэсгүүдэд хуваана. Иймд биссектрис нь 5 , $\frac{10}{3}$ катетуудтай тэгш өнцөг гурвалжны гипотенуз болно. Эндээс Пифагорын теоремоор

$$\ell = \sqrt{5^2 + \left(\frac{10}{3}\right)^2} = \frac{5\sqrt{13}}{3}$$

13.6. Багтсан тойргийн радиусыг r , гэвэл трапецийн өндөр буюу нэг хажуу тал нь $2r$ байна. Иймд тойрог багтаасан дөрвөн өнцөгтийн чанар ёсоор нөгөө хажуу тал нь

$$\ell = a + b - 2r$$


байна. Иймд Пифагорын теоремоор

$$(a + b - 2r)^2 = (2r)^2 + (a - b)^2 \Leftrightarrow$$

$$a^2 + b^2 + 4r^2 + 2ab - 4ar - 4br = 4r^2 + a^2 - 2ab + b^2 \Leftrightarrow$$

$$4ab = 4(a+b)r \Rightarrow r = \frac{ab}{a+b}$$

байна.




13.7. Квадратын талбай нь

$$S = a^2 = (2R \cos 45^\circ)^2 = \left(2R \frac{\sqrt{2}}{2}\right)^2 = 2R^2.$$

Дугуйн талбай πR^2 тул харьцаа нь $\frac{2R^2}{\pi R^2} = \frac{2}{\pi}$.

13.8.




$ABCDEFGH$ зөв найман өнцөгт O төвтэй тойрогт багтсан гэе. Тэгвэл

$\angle AOB = \frac{360^\circ}{8} = 45^\circ$ байна. Иймд AOB гурвалжны талбай

$$S_{\triangle AOB} = \frac{1}{2} \cdot AO \cdot BO \cdot \sin 45^\circ = \frac{1}{2} \cdot 3^2 \cdot \frac{\sqrt{2}}{2} = \frac{9\sqrt{2}}{4}.$$

Зөв найман өнцөгтийн талбай $8 \cdot \frac{9\sqrt{2}}{4} = 18\sqrt{2}$.

13.9.



Дугуйн радиусыг r гэвэл талбай нь πr^2 , багтсан квадратын талбай нь $4 \times \frac{1}{2}r^2 = 2r^2$ байна. Иймд

$$\pi r^2 - 2r^2 = 2\sqrt{3}(\pi - 2) \Rightarrow r^2 = 2\sqrt{3}$$

байна. Нөгөө талаас багтсан зургаан өнцөгт маань r талтай 6 ширхэг зөв гурвалжнаас тогтох тул талбай нь

$$S = 6 \times \frac{r^2 \sqrt{3}}{4} = \frac{6 \cdot 2\sqrt{3} \cdot \sqrt{3}}{4} = 9$$

байна.

13.10. $\begin{cases} 2x + x = 15 \\ x + y = 6 \end{cases}$ эсвэл $\begin{cases} 2x + x = 6 \\ x + y = 15 \end{cases}$ байна. Эхний тэгшитгэлээс $x = 5, y = 1$ тул талуудын урт 1, 10, 10 байна. Хоёр дахь тэгшитгэлээс $x = 2, y = 13$ болох ба энэ үед 13, 4, 4 нь гурвалжны тэнцэтгэл бишийг хангахгүй тул гурвалжны талууд байж чадахгүй.


13.11. $e^2 + f^2 = 2(5^2 + 6^2)$, $e + f = 5 + \sqrt{97}$ тул

$$2ef = (5 + \sqrt{97})^2 - 2(5^2 + 6^2)$$

буюу


$$ef = 5\sqrt{97}$$

тул $e = 5, f = \sqrt{97}$ эсвэл $e = \sqrt{97}, f = 5$ байна. Иймд параллелограммын богино диагональ 5 болно.



Зургаас ABD адил хажуут тул B оройгоос буусан BE өндөр нь медиан болно. Иймд $AE = \frac{6}{2} = 3$. Иймд Пифагорын теоремоор $BE = \sqrt{5^2 - 3^2} = 4$ болно. Иймд параллелограммын талбай нь $S = 6 \cdot 4 = 24$ байна.

13.12.




Огтлолцсон хөвчийн чанараар

$$x \cdot a = \frac{a}{2} \cdot \frac{a}{2} \Rightarrow x = \frac{a}{4}$$

тул $BD = a + \frac{a}{4} = \frac{5}{4}a$ байна.

13.13. Бага катетийн уртыг a гэвэл их катет нь $3a$ байна. Пифагорын теоремоор $a^2 + (3a)^2 = (2\sqrt{10})^2$ болно. Эндээс $10a^2 = 40$ болох тул $a = 2$. $S = \frac{a \cdot 3a}{2} = 6$ байна.




13.14. Гурвалжны периметр нь $6 + 10 + 12 = 28$ см байна.

$$6 = y + z, 10 = x + z, 12 = x + y \Rightarrow 2x = 16, 2y = 8, 2z = 4$$

таслагдсан гурвалжны периметр нь 16 тул 12 см талтай параллель шүргэгчээр үүсэх гурвалжин байна. $\triangle ALM \sim \triangle ABC$ тул

$$\frac{LM}{BC} = \frac{P_{\triangle ALM}}{P_{\triangle ABC}} \Rightarrow LM = \frac{16}{28} \cdot 12 = \frac{24}{7}$$

13.15. Шийдийн мужийг зургаар дүрсэлбэл

байна. Энэ нь 2 радиустай дугуйн $\frac{3}{4}$ хэсэг ба 2 катеттай адил хажуут тэгш өнцөгт гурвалжинд хуваагдах дүрс тул талбай нь


$$\frac{3}{4} \cdot \pi \cdot 2^2 + \frac{1}{2} \cdot 2 \cdot 2 = 3\pi + 2$$

байна.

13.16. Хажуу талсын талбайг S гэвэл суурь дээрх проекцийн талбай нь $S \cdot \cos \varphi$ байна. Хажуу гадаргуугийн талбай $3S$, суурийн талбай $3S \cdot \cos \varphi$ тул харьцаа нь

$$\cos \varphi = \frac{S \cos \varphi}{S} = \frac{3S \cos \varphi}{3S} = \frac{2}{3}$$

байна.


13.17.

Өндрийн суурийг O , хажуу ирмэгүүдийн уртыг $SA = SB = SC = \ell$ гэвэл Пифагорын теоремоор

$$OA^2 = OB^2 = OC^2 = \ell^2 - h^2$$

тул $OA = OB = OC$ байна. Иймд O багтаасан тойргийн төв юм.

13.18. Параллел хавтгайнуудыг огтлолж буй тул $BC \parallel MN$ байна. Нөгөө талаас $A_1M = MC_1$ тул MN нь $A_1B_1C_1$ гурвалжны дундаж шугам болно. Иймд A_1MN нь $\frac{a}{2}$ талтай зөв гурвалжин болно. Бидний олох зүйл нь дээд суурь нь $\frac{a}{2}$ талтай зөв гурвалжин, доод суурь нь a талтай зөв гурвалжин байдаг a өндөртэй огтлогдсон пирамидын эзлэхүүн юм.




Дээд суурийн талбай нь $S_1 = \frac{\sqrt{3} \cdot \left(\frac{a}{2}\right)^2}{4} = \frac{\sqrt{3}a^2}{16}$, доод суурийн талбай нь $S_2 = \frac{\sqrt{3}a^2}{4}$ тул огтлогдсон пирамидын эзлэхүүн нь

$$\begin{aligned} V &= \frac{1}{3} \left(\frac{\sqrt{3}a^2}{16} + \sqrt{\frac{\sqrt{3}a^2}{16} \cdot \frac{\sqrt{3}a^2}{4}} + \frac{\sqrt{3}a^2}{4} \right) a \\ &= \frac{1}{3} \left(\frac{\sqrt{3}a^2}{16} + \frac{\sqrt{3}a^2}{8} + \frac{\sqrt{3}a^2}{4} \right) a = \frac{7\sqrt{3}a^3}{48} \end{aligned}$$

13.19. Зааварт өгсөн хөндлөн огтлол нь 18 нэгж өндөртэй, багтсан тойргийн радиус нь 5 нэгжтэй тэнцүү адил хажуут гурвалжин байх ба суурийн урт нь пирамидын суурийн

талын урттай тэнцүү байна.



Гурвалжны талбай нэг талаас $S = pr = 5(x + y)$. нөгөө талаас $S = \frac{1}{2} \cdot 18 \cdot (2x) = 18x$ тул $18x = 5(x + y)$ буюу $y = \frac{13}{5}x$ болно. Пифагорын теорем ёсоор

$$x^2 + 18^2 = y^2 = \left(\frac{13}{5}\right)^2 x^2 \Rightarrow x = \frac{15}{2}$$

тул пирамидын суурийн талын урт $2x = 15$ байна. Иймд пирамидын эзлэхүүн

$$V = \frac{1}{3} 15^2 \cdot 18 = 1350$$

13.20. 6, 8, 10 талтай гурвалжин тэгш өнцөгт гурвалжин тул талбай нь $S = \frac{1}{2} \cdot 6 \cdot 8 = 24$ байна. Үүний 60° өнцөг үүсгэх хавтгай дээр проекц нь $24 \cos 60^\circ = 12$ талбайтай байна.

13.21.

$$\vec{m} \cdot \vec{n} = (-4) \cdot 2 + 2 \cdot (-2) + 2 \cdot 0 = -12$$

$$\vec{m} = \sqrt{(-4)^2 + 2^2 + 2^2} = 2\sqrt{6}$$

$$\vec{n} = \sqrt{2^2 + (-2)^2 + 0^2} = 2\sqrt{2}$$

Иймд

$$\cos \alpha = \frac{-12}{2\sqrt{6} \cdot 2\sqrt{2}} = -\frac{\sqrt{3}}{2}$$

байна. $\alpha \leq 180^\circ$ тул $\alpha = 150^\circ$ байна.

13.22. $\vec{a} + 2\vec{b} = -\frac{1}{2}(-2\vec{a} - 4\vec{b})$ тул $\vec{a} + 2\vec{b} \parallel -2\vec{a} - 4\vec{b}$ байна.

13.23.

$$AB: \frac{x-2}{-2-2} = \frac{y-(-3)}{4-(-3)}$$

тул

$$7x - 14 = -4y - 12 \Leftrightarrow 7x + 4y - 2 = 0$$

байна.

13.24. BC хэрчмийн дундаж цэг буюу медианы суурь нь:

$$M\left(\frac{-1+3}{2}; \frac{5+(-3)}{2}; \frac{2+4}{2}\right) = M(1; 1; 3)$$

байна. AM медианы урт нь

$$AM = \sqrt{(1-2)^2 + (1-(-3))^2 + (3-(-5))^2} = \sqrt{81} = 9.$$

13.25. $\vec{u} \cdot \vec{v} = 1 \cdot (-2) + 2 \cdot 1 = 0$, $\vec{u} \cdot \vec{u} = 1^2 + 2^2 = 5$. Иймд

$$\vec{u} \cdot (\vec{v} + 2\vec{u}) = \vec{u} \cdot \vec{v} + 2\vec{u} \cdot \vec{u} = 0 + 2 \cdot 5 = 10$$

14. Комбинаторик 1

14.1. $C_7^5 = C_7^{7-5} = C_7^2 = \frac{7 \cdot (7-1)}{2} = \frac{7 \cdot 6}{2} = 21$ байна.

14.2. $C_n^k = C_n^{n-k}$ тул $C_{20}^k = C_{20}^{20-k}$ байна.

14.3.

$$3 \cdot \frac{(x-1)(x-2)}{2!} + (x-2) \cdot 2 = 4 \cdot (x-2)(x-3) \Leftrightarrow$$

$$(x-2)(3x-3+4-8x+24) = 0 \Rightarrow x = 2, x = 5$$

гэсэн шийдүүд гарах ба A_{x-2}^2 нь $x \geq 4$ үед утгатай тул $x = 5$ байна.

14.4. $C_{10}^5 \cdot 2^5 \cdot 5^5 = \frac{6 \cdot 7 \cdot 8 \cdot 9 \cdot 10}{5!} \cdot 2^5 \cdot 5^5 = 63 \cdot 2^7 \cdot 5^5$.

14.5. Биномын хамгийн их коэффициент нь голын гишүүн буюу C_{12}^6 байна.

14.6. $\left(x^5 + \frac{1}{x^3}\right)^{50}$ биномын ерөнхий гишүүн нь

$$C_{50}^n (x^5)^{50-n} (x^{-3})^n = C_{50}^n x^{250-8n} = C_{50}^n x^{10}$$

тул $250 - 8n = 10 \Rightarrow n = 30$ байна.

14.7. Хорин тооноос 3 ба 4-ийн ядаж нэгэнд нь хуваагдах тоог шууд тоочоод олж болно. 3, 4, 6, 8, 9, 12, 15, 16, 18, 20 буюу 10 тоо байна. Цөөхөн элементтэй олонлогийн хувьд ийм бодолт хийхэд нэг их цаг орохгүй.

A -нь 3-т хуваагдах тоонуудын олонлог, B -нь 4-д хуваагдах тоонуудын олонлог гэвэл $|A| = [20/3] = 6$, $|B| = [20/4] = 5$ ба $A \cap B$ буюу хоёуланд нь зэрэг хуваагдах тоонуудын олонлогийн хувьд $|A \cap B| = \left[\frac{20}{3 \cdot 4}\right] = 1$ байна. Ядаж нэгэнд нь хуваагдах тоонуудын олонлог нь $A \cup B$ тул

$$|A \cup B| = |A| + |B| - |A \cap B| = 6 + 5 - 1 = 10.$$

14.8. $a = 1$ үед $1 \leq b \leq 29$ буюу 29 хос, $a = 2$ үед $1 \leq b \leq 28$ буюу 28 хос, ..., $a = 29$ үед $1 \leq b \leq 1$ буюу 1 хос байна. Нийт

$$29 + 28 + \dots + 1 = \frac{29+1}{2} \cdot 29 = 435.$$

14.9. $A = 3^1 \cdot 5^1 \cdot 7^1$ тул хуваагчдын тоо нь

$$(1 + 1)(1 + 1)(1 + 1) = 8$$

байна

14.10. Эхний цифрийг 9 янзаар сонгоод түүний араас 2 дахь цифрийг 10 янзаар сонгож болох тул эхний хоёр цифрийг нийт 90 янзаар сонгож болно. 3 дахь цифрийг эхний хоёр нь ямар тоо байхаас үл хамааран 10 янзаар сонгож болох тул эхний гурван цифрийг 900 янзаар, эхний 4 цифрийг 9000 ялгаатай аргаар сонгож болно. Сүүлийн цифрийг 5 янзаар сонгох тул нийт $9 \cdot 10 \cdot 10 \cdot 10 \cdot 5 = 45000$ ширхэг цифрүүдийн нийлбэр сондгой 5 оронтой тоо байна.

14.11. $n = 4$ үед 2, 6, 4, 12, 4 гэсэн утгууд өгч байна. Нөгөө талаас гүдгэр 4 өнцөгт 2 диагональтай тул А хариулт зөв байна.

14.12. Бидний хувьд $a \in \text{НОМ}$, $b \in \text{ДЭВТЭР}$ байх (a, b) хосуудын тоог олно. $|\text{НОМ}| = 3$, $|\text{ДЭВТЭР}| = 5$ тул үржвэрийн зарчим ёсоор $3 \cdot 5 = 15$ янзаар (a, b) хосыг бүрдүүлж болох тул ном ба дэвтрийг 15 янзаа сонгон авч болно.

14.13. Нийт $C_5^3 = 10$ янзаар 3 орой сонгож болох бөгөөд эдгээрийн нэг нь гурвалжин үүсгэхгүй тул $10 - 1 = 9$ гурвалжин байна.

14.14. Дөрвөн хүүг C_{20}^4 янзаар сонгож болох бөгөөд тухай бүрт нь хоёр охиныг нь C_{10}^2 янзаар сонгож болох тул $C_{20}^4 C_{10}^2$ байна.

14.15. Дурын хоёр сурагч сонгон авах бүрд яг нэг өрөг харгалзах тул

$$C_{10}^2 = \frac{10 \cdot (10 - 1)}{2} = 45$$

өрөг гарна.

14.16. 10-д хуваагдах тул 0 цифр заавал орох ёстой. Цифрүүд нь буурах эрэмбээр байрлах ёстой тул цифр давтагдахгүй. Үлдэх 4 цифрийг C_9^4 янзаар сонгох ба эдгээр цифрүүдийг 0-тэй нийлүүлээд цор ганц аргаар буурах эрэмбээр байрлуулж болно. Мэдээд 0 цифр хамгийн сүүлийн байранд байрлах тул 10-д хуваагдах тоонууд байна. Иймд зөв хариулт нь C_9^4 .

14.17. Хамгийн дээд талын өнгийг 3 янзаар, хоёр дахийг 2 янзаар, гурав дахь нь үлдсэн өнгө нь байх тул $3 \cdot 2 \cdot 1 = 6$ янзаар хөндлөн судалтай далбаа хийж болно.

14.18. Бидний олох тоо нь $\{1, 3, 5, 7, 9\}$ цифрүүдээс 3-ийг нь нэг эгнээнд жагсааж бичих боломжийн тоо буюу

$$A_5^3 = \frac{5!}{(5-3)!} = 3 \cdot 4 \cdot 5 = 60$$

байна.

14.19. Эхний сурагчийг 20 янзаар, хоёр дахийг 19 янзаар, гурав дахийг 18 янзаар, дөрөв дэхийг 17 янзаар, тав дахийг 16 янзаар суулгаж чадна. Иймд $20 \cdot 19 \cdot 18 \cdot 17 \cdot 16 = A_{20}^5 = 5!C_{20}^5$.

Санамж: Үүнийг 20 сандалаас 5 сурагчид суудал сонгох гэж үзээд шууд A_{20}^5 гэж бодож болно. Сурагчид ялгаатай тул суудал сонголт нь эрэмбэтэй байна. Өөрөөр хэлбэл Бат 1-р сандал дээр, Дорж 2-р сандал дээр суух нь Бат 2-р сандал дээр, Дорж 1-р сандал дээр суухаас ялгаатай байна.

14.20. 3 төрлийн цэцгээс 5-ийг сонгох тул $C_{(3)}^5 = C_{3+5-1}^5 = C_7^5$ байна.

14.21. Нийт 5 оронтой тоонуудын тоо $99999 - 9999 = 9 \cdot 10^4$ байна. Эдгээрийн урд эхний цифрийг нь бичвэл бодлогын нөхцөлийг хангах тоо үүсэх бөгөөд эдгээрээс өөр тоо байж болохгүй нь ойлгомжтой юм.

Энэ бодлогыг өөрөөр

$$\overline{a_1 a_2 a_3 a_4 a_5 a_6} \leftrightarrow (a_1, a_2, a_3, a_4, a_5, a_6)$$

байх 6-тийн тоог тоолж бодож болно. a_1 -ийг 0-ээс ялгаатай байхаар 9 янзаар, a_2 -ийг a_1 -тэй тэнцүү байхаар цор ганц аргаар, бусдийг нь тус бүр 10 янзаар сонгож болох тул ийм 6-тийн тоо нь

$$9 \cdot 1 \cdot 10 \cdot 10 \cdot 10 \cdot 10 = 9 \cdot 10^4$$

байна.

14.22. МАТЕМАТИК үгэнд М үсэг 2 удаа, А үсэг 2 удаа, Т үсэг 2 удаа, Е үсэг 1 удаа, И үсэг 1, К үсэг 1 удаа орсон тул 2, 2, 2, 1, 1, 1 бүтэцтэй давталттай сэлгэмэлийн тоог олно.

$$P(2, 2, 2, 1, 1, 1) = \frac{(2+2+2+1+1+1)!}{2! \cdot 2! \cdot 2! \cdot 1! \cdot 1! \cdot 1!} = \frac{9!}{8} = 45360$$

14.23. Нийт боломжийн тоо нь $P(3, 1, 1) = \frac{(3+1+1)!}{3! \cdot 1! \cdot 1!} = \frac{5!}{3!} = 20$. Үүнээс гурван Э үсэг

зэрэгцэж орсон нь $P(1, 1, 1) = \frac{(1+1+1)!}{1! \cdot 1! \cdot 1!} = 6$ тул бидний олох боломжийн тоо $20 - 6 = 14$ байна.

14.24. Цифр бүр нэгж, аравт, зуутын оронд тус бүр 100 удаа орно. Жишээ нь $\overline{ab1}$ хэлбэрийн тооны хувьд a, b нь тус бүрдээ 10, 10 боломжтой тул нийт $10 \cdot 10 = 100$ боломж байна ($0a1$ -г $\overline{a1}$ гэж үзнэ). Иймд цифр 300 удаа орох тул эдгээр тоонуудын цифрүүдийн нийлбэр нь

$$300(0+1+2+\dots+9) = 300 \cdot 45 = 13500$$

байна.

14.25. Дан бодтой байхын тулд зөвхөн адуу, үхэр, тэмээ буюу 3 төрлийн малтай байна. Иймд $C_{(3)}^{10} = C_{3+10-1}^{10} = C_{12}^{10} = 66$.

Нийт боломжийн тоо $C_{(5)}^{10}$, нэг ч адуугүй байх боломжийн тоо $C_{(4)}^{10}$ тул ядаж нэг адуутай байх боломжийн тоо

$$C_{(5)}^{10} - C_{(4)}^{10} = C_{5+10-1}^{10} - C_{4+10-1}^{10} = C_{14}^{10} - C_{13}^{10} = 715.$$

Яг гурван хоньтой бол үлдэх 7 нь 4 төрлийнх байх тул

$$C_{(4)}^7 = C_{4+7-1}^7 = C_{10}^7 = 120$$

байна.

15. Магадлал, Статистик 1

15.1. Мэдээж шидсэн чулуу татах хүчний нөлөөгөөр эргэж унах ёстой тул гарцаагүй үзэгдэл байна.

15.2.

1. B, D, F дүн авах нь A дүн авах ба C дүн авах үзэгдлүүдийн алинд ч орохгүй тул эсрэг үзэгдлүүд байж чадахгүй.
2. B -ээс их дүн авах ба C -ээс их дүн авах үзэгдэлд агуулагдах ба эдгээрийн алинд ордоггүй D, F дүн авах боломжууд байгаа тул эсрэг үзэгдлүүд байж чадахгүй.
3. Эсрэг үзэгдлүүд байж чадна.
4. Тэгш өнцөгт гурвалжин эдгээрийн алинд орохгүй.
5. 1 нь натурал тоо бөгөөд анхны ч тоо биш, зохиомол ч тоо биш юм.

15.3. Тус бүрдээ $\frac{3}{6} = \frac{1}{2}$ магадлалтайгаар 3-аас ихгүй тоогоор буух бөгөөд хоёулаа зэрэг 3-аас ихгүй байх үзэгдэлийн магадлал нь $\frac{1}{2} \cdot \frac{1}{2} = \frac{1}{4}$ байна. Эсрэг үзэгдэл буюу ядаж 1 нь 3-аас их тоогоор буух үзэгдлийн магадлал нь $1 - \frac{1}{4} = \frac{3}{4}$ байна.

15.4. Нийцгүй үзэгдлүүд тул эдгээр үзэгдлийн ядаж нэг нь явагдах магадлал нь магадлалуудын нийлбэртэй тэнцүү байна. Иймд

$$0.1 + 0.2 + 0.3 + 0.25 = 0.85$$

15.5.

$$|M \cup A| = |M| + |A| - |M \cap A| = 10 + 8 - 5 = 13$$

тул $|\overline{M \cup A}| = 20 - 13 = 7$ байна. Иймд санамсаргүйгээр сонгосон нэг сурагч ямар нэг дугуйланд явдаггүй байх магадлал $\frac{7}{20}$.

15.6. A нь 1-р довтлогч цохиолтоо алдах үзэгдэлд; B_1, B_2 нь 2-р довтлогч эхний ба удаах цохилтоо алдсан байх үзэгдэлүүд байг. Тэгвэл эдгээр нь хамаарахгүй үзэгдлүүд гэж үзэж болох тул бидний олох магадлал

$$P(AB_1B_2) = P(A)P(B_1)P(B_2) = (1 - 0.2)(1 - 0.3)(1 - 0.3) = 0.8 \cdot 0.7^2 = 0.392$$

15.7. $a_n = 26 \cdot n = 988 \Rightarrow n = \frac{988}{26} = 38$ байна. Нийт 1000 тоо байгаа тул тэдгээрийг нэгийг нь сонгоход 13-т хуваагдах тэгш тоо байх магадлал нь $\frac{38}{1000} = 0.038$ байна.

15.8. Хоёр ялгаатай тоо сонгон авах боломжийн тоо $C_{10}^2 = \frac{10!}{2!8!} = 45$. Дараалсан хоёр тоо байх боломжууд нь

$$\{1, 2\}; \{2, 3\}; \{3, 4\}; \dots; \{9, 10\}$$

гэсэн 9 боломж бий. Иймд магадлал нь $\frac{9}{45} = 0.2$ байна.

15.9. $P = \frac{\text{Ивээдэг эгэл үзэгдлийн тоо}}{\text{Нийт эгэл үзэгдлийн тоо}} = \frac{3}{216} = \frac{1}{72}$.

15.10. Яг нэг нь гологдол байх боломжийн тоо нь 1 ш гологдол, 2 ш хэвийн бүтээгдэхүүнээс тогтох тул

$$C_3^1 \cdot C_9^2 = 3C_9^2$$

боломжтой. Нийт боломжийн тоо C_{12}^3 тул бидний олох магадлал $\frac{3C_9^2}{C_{12}^3}$ -тэй тэнцүү байна.

15.11. 5 цифр орсон тоонууд нь 5, 15, 25, 35, 45, 50, 51, ..., 59, 65, 75, 85, 95 буюу нийт 19 ширхэг байгаа. Иймд санамсаргүйгээр сонгосон билетийн дугаарт 5 цифр орсон байх магадлал $\frac{19}{100}$ байна.

15.12. $a - b = 21$, $a - b = 22$, ..., $a - b = 99$ байх хосуудын тоог тоолъё. $a - b = 21$ байх хосууд нь $(a; b) = (22; 1), (23; 2), \dots, (100, 79)$ тул 79 ширхэг байна. Үүнтэй ижлээр $a - b = 22$ байх хосын тоо 78, $a - b = 23$ байх хосын тоо 77 гэх мэтчилэн $a - b = 99$ байх хос нь $(100; 1)$ буюу 1 ширхэг байх тул $a - b > 21$ байх хосын тоо


$$1 + 2 + \dots + 79 = \frac{1 + 79}{2} \cdot 79 = 3160$$

ба нийт хосын тоо $C_{100}^2 = \frac{99 \cdot 100}{2} = 4950$ тул бидний олох магадлал $\frac{3160}{4950} = \frac{316}{495}$ байна.

15.13. Будагдсан хэсгийн талбай нийт талбайн хагас тул $\frac{1}{2}S$ байна. Бид геометр магадлал бодох ёстой тул $P = \frac{\frac{1}{2}S}{S} = \frac{1}{2}$. Үүнийг өөрөөр будагдсан ба будагдаагүй хэсэгт унах магадлал ижил ба нийлбэр нь 1 тул тус бүрдээ $\frac{1}{2}$ магадлалтай гэж бодож болно.

15.14. Нэгж радиустай дугуйн талбай π байна. Дугуйн төвөөс $\frac{1}{6}$ -ээс бага зайд байх цэгүүдийн геометр байр нь $\frac{1}{6}$ радиустай төв нь дугуйн төвтэй давхцах дугуй байна.

$$P = \frac{\pi \times \left(\frac{1}{6}\right)^2}{\pi \times 1^2} = \frac{1}{36}$$



15.15. Эхэлж улаан бөмбөг гарч ирэх үзэгдлийг A , хоёр дахь бөмбөг нь хөх байх үзэгдлийг B гэе. $P(A) = \frac{5}{9}$, $P_A(B) = \frac{4}{8}$ тул

$$P(AB) = P(A) \cdot P_A(B) = \frac{5}{9} \cdot \frac{4}{8} = \frac{5}{18}$$

байна.

15.16. Цагаан уутнаас улаан бөмбөг улаан уутанд хийсэн байх эгэл үзэгдлийн тоо $4 \cdot 7 = 28$. Эдгээрээс хамгийн сүүлд улаан бөмбөг гарсан байх нь $4 \cdot 3 = 12$. Цагаан уутнаас хөх бөмбөг улаан уутанд хийсэн байх эгэл үзэгдлийн тоо $3 \cdot 7 = 21$. Эдгээрээс хамгийн сүүлд улаан бөмбөг гарсан байх нь $3 \cdot 2 = 6$ байна. Иймд нийт эгэл үзэгдлийн тоо $28 + 21 = 49$ ба эдгээрээс $12 + 6 = 18$ -д нь улаан уутнаас улаан бөмбөг гарч ирэх үзэгдэл тул магадлал нь $\frac{18}{49}$ байна.

Нэмэлт: Үүнийг бүтэн магадлалын томъёо ашиглан:

$$P = \frac{4}{7} \cdot \frac{3}{7} + \frac{3}{7} \cdot \frac{2}{7} = \frac{18}{49}$$

гэж бодож болох ба эдгээр бодолтууд нь үнэн чанартай нэг бодолт юм.

15.17. A - сонгогдсон харваач 2 удаа харвахад сум байг оноогүй байх үзэгдэл, B_i - i -р харваач харвасан байх үзэгдэл. Тэгвэл

$$P(A|B_1) = (1 - 0.3)^2 = 0.7^2 = 0.49$$

$$P(A|B_2) = (1 - 0.5)^2 = 0.5^2 = 0.25$$

$$P(A|B_3) = (1 - 0.8)^2 = 0.2^2 = 0.04$$

ба $P(B_k) = \frac{1}{3}$ байна. Иймд бидний олох магадлал

$$\begin{aligned} P(B_1|A) &= \frac{P(B_1) \cdot P(A|B_1)}{P(B_1) \cdot P(A|B_1) + P(B_2) \cdot P(A|B_2) + P(B_3) \cdot P(A|B_3)} \\ &= \frac{\frac{1}{3} \cdot 0.49}{\frac{1}{3} \cdot 0.49 + \frac{1}{3} \cdot 0.25 + \frac{1}{3} \cdot 0.04} = \frac{0.49}{0.78} = \frac{49}{78} \end{aligned}$$

15.18.

$A = \{\text{таамгаар сонгон авсан эдлэл гологдол байх}\}$

$B_i = \{\text{энэ эдлэлийг } k\text{-р машин үйлдвэрлэсэн байх}\}$

үзэгдлүүд бол B_1, B_2, B_3 үзэгдлүүд нь хос хосоороо нийцгүй ба нийлээд A үзэгдлийг агуулна. Иймээс бүтэн магадлалын томъёо ашиглаж бодъё. Бодлогын нөхцөл ёсоор

$$P(B_1) = 0.30, P(B_2) = 0.25, P(B_3) = 0.45$$

ба

$$P(A|B_1) = 0.02, P(A|B_2) = 0.01, P(A|B_3) = 0.03$$

тул

$$\begin{aligned} P(A) &= P(B_1) \cdot P(A|B_1) + P(B_2) \cdot P(A|B_2) + P(B_3) \cdot P(A|B_3) \\ &= 0.30 \cdot 0.02 + 0.25 \cdot 0.01 + 0.45 \cdot 0.03 = 0.022 \end{aligned}$$

15.19. A улаан уутнаас 2 бөмбөг авах үзэгдэл, B хөх уутнаас 2 бөмбөг авах үзэгдэл. C нь гарч ирсэн хоёр бөмбөг хоёулаа улаан байх үзэгдэл гэвэл $P(A) = P(B) = \frac{1}{2}$,

$$P_A(C) = \frac{C_5^2}{C_8^2} = \frac{5}{14}, P_B(C) = \frac{C_3^2}{C_7^2} = \frac{3}{21} \text{ тул бүтэн магадлалын томъёогоор}$$

$$\begin{aligned} P(C) &= P_A(C) \cdot P(A) + P_B(C) \cdot P(B) \\ &= \frac{5}{14} \cdot \frac{1}{2} + \frac{1}{7} \cdot \frac{1}{2} = \frac{1}{4} \end{aligned}$$

15.20.

$$E(X) = (-2) \cdot 0.1 + (-1) \cdot 0.2 + 0 \cdot 0.3 + 1 \cdot 0.2 + 2 \cdot 0.2 = 0.2$$

байна.

15.21. X_n нь шоог n -р удаад орхиход тусах тоо гэвэл X_n -ийн математик дундаж нь

$$EX_n = 1 \cdot \frac{1}{6} + 2 \cdot \frac{1}{6} + 3 \cdot \frac{1}{6} + 4 \cdot \frac{1}{6} + 5 \cdot \frac{1}{6} + 6 \cdot \frac{1}{6} = 3.5$$

Санамсаргүй хувьсагчуудын нийлбэрийн математик дундаж нь тэдгээрийн математик дунджаудын нийлбэр тул

$$E(X_1 + X_2 + \dots + X_n) = EX_1 + EX_2 + \dots + EX_{100} = 100 \cdot 3.5 = 350$$

15.22. X санамсаргүй хувьсагчийн математик дундаж нь

$$E(X) = (-2) \cdot 0.1 + (-1) \cdot 0.2 + 0 \cdot 0.4 + 1 \cdot 0.2 + 2 \cdot 0.1 = 0$$

байна.

$$Var(X) = E(X^2) - E^2(X) = E(X^2)$$

тул

$$Var(X) = (-2)^2 \cdot 0.1 + (-1)^2 \cdot 0.2 + 0^2 \cdot 0.4 + 1^2 \cdot 0.2 + 2^2 \cdot 0.1 = 1.2$$

15.23.

$$E(X) = 0 \cdot 0.3 + 1 \cdot 0.5 + 2 \cdot 0.2 = 0.9$$

ба

$$E(X^2) = 0^2 \cdot 0.3 + 1^2 \cdot 0.5 + 2^2 \cdot 0.2 = 1.3$$

тул дисперс нь

$$Var(X) = 1.3 - 0.9^2 = 1.3 - 0.81 = 0.49$$

байна. Иймд стандарт хазайлт нь

$$\sigma(X) = \sqrt{0.49} = 0.7$$

байна.

15.24. Бүх боломжит үр дүн нь (1;2), (1;4), (1;6), (1;8), (3;2), (3;4), (3;6), (3;8), (5;2), (5;4), (5;6), (5;8), (7;2), (7;4), (7;6), (7;8), (9;2), (9;4), (9;6), (9;8) гэсэн 20 хос байна. Эдгээрээс А хүн хожих нь (3;2), (5;2), (5;4), (7;2), (7;4), (7;6), (9;2), (9;4), (9;6), (9;8) гэсэн 10 хос юм.

Иймд А хүн хожих магадлал $\frac{10}{20} = \frac{1}{2}$ байна.

А хүн хожигдох буюу 0 оноо авах магадлал $\frac{1}{2}$ байх нь ойлгомжтой. 1 оноо аваад хожих боломжгүй тул магадлал нь 0, 3 оноо аваад хожих (3;2) гэсэн 1 боломжтой тул магадлал нь $\frac{1}{20}$, 5 оноо аваад хожих (5;2), (5;4) гэсэн 2 боломжтой тул магадлал нь $\frac{2}{20}$, 7 оноо аваад хожих (7;2), (7;4), (7;6) гэсэн 3 боломжтой тул магадлал нь $\frac{3}{20}$, 9 оноо аваад хожих (9;2), (9;4), (9;6), (9;8) гэсэн 4 боломжтой тул магадлал нь $\frac{4}{20}$ байна. Иймд авах онооны математик дундаж нь

$$0 \cdot \frac{1}{2} + 1 \cdot 0 + 3 \cdot \frac{1}{20} + 5 \cdot \frac{2}{20} + 7 \cdot \frac{3}{20} + 9 \cdot \frac{4}{20} = \frac{70}{20} = \frac{7}{2}$$

байна.

15.25.

